



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 22 өдөр

Дугаар А/236


Хэрлэн сум

Цэргийн бэлтгэл албаны 2 дугаар зэргийн
үүрэгтний сургалт зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагын тухай хуулийн 66 дүгээр зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1, Батлан хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.6, Цэргийн албаны тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.8, Батлан хамгаалахын сайдын Хэнтий аймгийн Засаг даргатай 2022 онд хамтран ажиллах гэрээний 3.8 дахь заалт, Батлан хамгаалахын сайдын 2022 оны н/11 дугаар тушаалыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Цэргийн бэлтгэл албаны 2 дугаар зэргийн үүрэгтний сургалтыг 5 дугаар сарын 24-ний өдрөөс эхлэн зохион байгуул сугай.
2. Сургалтыг зохион байгуулах албан тушаалтнууд болон хамрагдах бэлтгэл үүрэгтний нэрсийн жагсаалтыг хавсралтаар баталсугай.
3. Сургалтад хамрагдах цэргийн бэлтгэл үүрэгтэн нэг бүрт мэдэгдэх хуудас өгч бүрэн оролцуулахыг сумдын Засаг дарга нарт, Батлан хамгаалахын сайдын 2018 оны А/313 дугаар тушаалаар батлагдсан хөтөлбөрийн дагуу сахилга, зохион байгуулалтын өндөр хэмжээнд явуулж дүнг илтгэхийг Цэргийн штаб (хурандаа Н.Хүрэлээ)-т, сургалт зохион байгуулахад шаардлагатай санхүүжилтийг олгож, хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Ганбаатар)-д тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

231010004